

БИО ЁС ЗҮЙ БА ХҮҮХДИЙН ЭРХ

Ж. Баттогтох *

Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын эрх зүйн салбарт хүүхдийн эрхийн тусгай хамгаалалтын асуудлууд байдаг. Тусгай хамгаалалтын асуудалд хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн дараах асуудлууд ордог. Үүнд:

1. Хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс хамгаалах
2. Хүүхдийг эдийн засгийн мөлжлөгөөс хамгаалах
3. Био ёс зүй ба хүүхдийг салбарт хамгаалах

Өнөөдөр анагаах ухаан хүүхдийн хүйсийг тодорхойлох, хэвлий дэх ургийн өсөлт, хөгжилд хяналт тавих, хүний амь насыг аврах, орчин үед гарч байгаа олон янзын шинэ бөгөөд аюултай өвчин эмгэгийг эдгээхэд биологи болон анагаах ухааны салбарт гарч буй ололт амжилтууд хувь нэмрээ оруулж байна.

Хүн төрөлхтөн XX зуунд сахуу, татранги, халдварт саа гэх мэт өвчнийг анагаах зорилгоор вакцин тариурыг бий болгож чадсан. Сүүлийн 10 жилд биологи болон эрүүл мэндийн салбарын эрдэмтэд удамшлын сангийн асуудалд анхаарлаа хандуулж, судалж байна. Уг салбарт гарах болсон судалгаа, ололттой зүйлүүд нь ёс суртахуун ба ёс зүйн асуудлуудыг хөндөх болсон ба хүний жам ёсны амьдралын хэв маягт өөрчлөлт оруулж эхэлсэн. Иймээс өнөө үед хүний эрхийг хамгаалах асуудал дээр био ёс зүйн асуудлуудыг эрх зүйтэй холбож судлах нь зайлшгүй шаардлагатай болж байгаа бөгөөд хүний эрхийг зөрчиж байгаа олон сөрөг үзэгдлүүд үүнийг дагаад гарах болсон.

Грек хэлнээс “био ёс зүй” гэдэг нэр томъёог хөрвүүлбэл “амьдралын ёс зүй” гэсэн утгатай үг болно. “Био ёс зүй” нь нэг талаас философийн салбар судлагдахуун, нөгөө талаас анагаах ухаан, биологи, хууль зүй, нийгмийн ухаануудыг хамрах судлагдахуун гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл эмч, хуульч, социологич, философич нар хамтран судлах шинжлэх ухааны шинэ салбар юм. Эрх зүйн ном зохиолд “био ёс зүй” ба биологи, анагаах ухааны ёс зүй гэсэн 2 ойлголт байдаг. ОХУ-ын Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч, академич В.И Покровский дээрх 2 ойлголт адил утгатай ба Гиппократын тангараг дээр үндэслэгдсэн ойлголт гэж үзэв. В.И Покровскийн тайлбарлаж байгаагаар “био ёс зүй” нь анагаах ухаанд гарч буй зарим нэгэн нээлт хүний эрхийг гажуудуулж, хүнд сөргөөр нөлөөлж байна гэж үзэн ёс суртахуун болон хууль зүйн хэм хэмжээг уг салбарт гаргах шаардлагатай байгаа шинжлэх ухааны нэг судлагдхуун гэж тайлбарлав.¹

ОХУ-ын эрдэмтэн, судлаач Н.Е. Крылова “био ёс зүй” нь хувь хүнийг эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилтаас хамгаалах эрх зүйн салбар гэж

* МУИС, ОУХС-ийн дэд профессор, доктор (Ph.D)

¹ Биомедицинская этика. //Под. ред. В.И. Покровского. Москва, 1997. Стр.4.

үзэв. Өөрөөр хэлбэл, хүн бүр төрж мэндлэхдээ эрх чөлөөтэй, адилхан нэр төртэй, ижил эрхтэй, оюун ухаан, нандин чанар заяасан хүн ямар ч тохиолдолд шинжлэх ухааны золиос болж болохгүй юм.²

1997 оны “Био ёс зүйн тухай хуулийн үндэс ба түүнийг хэрэгжүүлэх тухай” ОХУ-ын хуулинд “био ёс зүй” гэдэг ойлголтыг тайлбарласан байдаг. Уг хуулийн оршил хэсэгт анагаах ухааны салбарт гарч буй нээлт хүний эрхийн асуудлыг хэрхэн хөндөж байгааг тусгасан. 1997 оны хуулийн зүйл ангиудад уг салбарт хүний эрхийг хамгаалах үндсэн зарчим, хэм хэмжээг оруулсан. Хүний эрхтэнг түүний зөвшөөрөлгүйгээр шилжүүлэн суулгах, хүний удмын санд өөрчлөлт оруулах, клоны аргаар амьд бие бий болгох, хүн дээр туршилт хийх г.м. асуудлуудыг дээрх хуулиар хориглосон ба хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлсэн байна.

Олон улсын эрх зүйд “био ёс зүй”-н салбар дахь тулгамдсан асуудлуудыг шийдэх зорилгоор хэд хэдэн гэрээ конвенцууд бий болсон. Био ёс зүйн асуудал хамгийн анх 1946 онд Нюрнбергийн олон улсын шүүх дээр хөндөгдсөн билээ. Дэлхийн II дайны үед Нацист Германы эмч нар олон мянган олзлогсод дээр туршилт хийжээ. Нюрнбергийн шүүх хурал дээр 23 эмчийг шүүхэд татсан ба 7 эмчид нь дээд хэмжээний ял оногдуулсан юм. Био ёс зүйн хамгийн анхны эрх зүйн бичиг баримт Нюрнбергт боловсруулагдсан бөгөөд үүнийг “Нюрнбергийн кодекс” гэсэн.³ Уг хуулинд анагаах ухааны нээлт хийх зорилгоор анх удаа хүн дээр туршилт хийх, хүний эд эрхтэнг ашиглахыг хориглосон. “Нюрнбергийн кодекс”-т тусгагдсан хэм хэмжээ, зарчмууд нь заавал биелэгдэх шинж чанар агуулаагүй ба ёс суртахууны хэм хэмжээг түлхүү оруулж өгсөн. Гэхдээ хуулинд хүн дээр огт туршилт хийж болохгүй гэж заагаагүй. Хүн дээр туршилт хийхийн тулд юуны өмнө хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах, туршилтанд орж буй хүн сайн дурын үндсэн дээр зөвшөөрлөө өгөх, мөн хүний бие даан шийдвэр гаргах эрх зүйн чадварыг харгалзан үзэх, туршилтанд орох зөвшөөрлөө олгосон хүнд эмч нар, эрдэмтэд хийж буй туршилтынхаа зорилгыг тайлбарлах, гарч болох үр дагаврыг үнэн зөвөөр мэдэгдэх ёстой. Эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилт тухайн нийгэмд ямар эерэг сөрөг талтай байх вэ гэдгийг эрдэмтэд харгалзах ёстой гэж заажээ. Туршилтанд орогч нь бие физиологийн хувь болон сэтгэл зүйн хувьд ямар нэгэн байдлаар хохирох ёсгүй ба туршилтын багаж, тоног төхөөрөмж нь хүний амь насанд аюул учруулахгүй байх, хүнийг гэмтээж тахир дутуу болгохгүй байх ёстой. Уг хуулийн онцлог бол ёс зүй болон эрх зүйн хэм хэмжээний үндсэн зарчмуудыг шинээр бий болгосонд оршино.

Био ёс зүйн талаарх дараагийн олон улсын эрх зүйн гол бичиг баримт бол 1966 оны “Иргэний болон улс төрийн эрхийн тухай” олон улсын пакт юм. Уг пактын 7-р зүйлд “хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэнтэй ч хэрцгий, хүний ёсноос гадуур, эсхүл нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Тухайлбал, өөрийн нь зөвшөөрөлгүйгээр хэн дээр ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилт хийж болохгүй” гэжээ.⁴

1993 онд ЮНЕСКО нь “Био ёс зүйн олон улсын хороо” (UNESCO International Bioethics Committee)-г байгуулсан. Уг хороонд 36 бие даасан шинжээчид ажилладаг. Уг шинжээчдийн ихэнх нь хуульч, эдийн засагч,

² Крылова Н.Е. Об уголовно-правовой защите прав человека от общественно опасных

³ Рекунков А.М. Нюрнбергский процесс. Том 5. Москва, 1997. Стр.154.

⁴ Действующее международное право в двух томах. Сост. Ю.М. Колосов и Э.С. Кривчикова. Том 1. М.: Международные отношения, 2002.

философич, улс төрч мэргэжилтэй хүмүүс бий. Био ёс зүйн олон улсын хорооны даргаар Токиогийн Их сургуулийн профессор, Олон улсын эрх зүйн холбооны гишүүн Рюичи Ида ажилладаг юм.

1997 онд ЮНЕСКО-ын Ерөнхий Чуулганаар “Хүний удмын сан ба хүний эрхийн тухай” НҮБ-ын Түгээмэл тунхаглалыг баталсан юм.⁵ Энэ бичиг баримт нь био ёс зүйн салбар дахь хамгийн анхны түгээмэл эрх зүйн бичиг баримт болсон юм. Уг тунхаглалын оршил хэсэгт ЮНЕСКО-ын зорилго, хүний эрхийн салбарт гарсан НҮБ-ын баримт бичгүүдэд тусгагдсан зарчим орсон юм. “Хүний удмын сан ба хүний эрхийн тухай” тунхаглалд өөр бусад эрх зүйн салбар дахь хуулийн хэм хэмжээ тусгалаа олсон.⁶ Тухайлбал, оюуны өмчийн, биологийн төрөл зүйлийн, эмчийн ёс зүйн тухай хуулийн хэм хэмжээ гэх мэт. Тус тунхаглалд био ёс зүйн 3 шинэ зарчим бий болсон. Энэ нь хүний удмын сангийн хамгаалалт; хүн бүрийн нэр төр, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх; ямар ч тохиолдолд хүүхэд дээр туршилт хийхгүй байх гэсэн зарчим юм.

Тунхаглал батлагдсаны дараа түүний гишүүн улсууд өөрийн дотоодын хууль тогтоомжоо нийцүүлэн уялдуулсан байна. Испани улсын Овьедод “Био ёс зүйн салбарт хүний эрхийг хамгаалах тухай” олон улсын хурал болж уг хурлаас дараагийн олон улсын эрх зүйн бичиг баримт болох “Биологи ба анагаах ухааны салбарт хүний эрх, эрх чөлөө, нэр хүндийг хамгаалах тухай” 1996 оны Европын Холбооны конвенци гарсан юм.

Уг Конвенци нь био ёс зүйн салбарт гарсан хамгийн анхны бүс нутгийн олон улсын эрх зүйн баримт бичиг болсон юм. Конвенцийн оршил хэсэг шинжлэх ухаан болон нийгмийн ашиг сонирхлоос дээгүүр хүний ашиг сонирхол тавигдах ёстой гэсэн утга санааг агуулсан байна. Мөн “улс бүр иргэнийхээ эрх ашгийг анагаах ухааны салбарт хамгаалах, эрүүл мэндийн анхан шатны тусламжийг хүн бүрт адил тэгш олгох, уг тусламж нь эрүүл мэндийн стандартад нийцсэн байх ёстой” гэжээ. Конвенцийн онцлог гэвэл, био ёс зүйн салбарт хүний эрхийг хамгаалах хэм хэмжээнүүдийг төрөлжүүлэн эмхэтгэн, дэвшилттэйгээр хөгжүүлэх алхам болсон явдал юм. Европын холбооны дээрх Конвенци нь нэгдүгээрт хүний эрхийн асуудал дээр анагаах ухааны оролцооны дээд, доод хязгаарыг тавьж өгсөн, хоёрдугаарт туршилтанд орж буй хүн мэдээллээр хангагдсан байх, гуравдугаарт хувь хүний зөвшөөрсний үндсэн дээр туршилт хийгдэх, дөрөвдүгээрт насанд хүрээгүй хүн ба өөрийн эрүүл мэндийн асуудал дээр шийдвэр гаргах чадамжгүй этгээдэд туршилт хийхгүй байх ёстой гэсэн зүйлүүдийг хуульчилсан юм. Дээрх конвенцийн төслийг боловсруулж байх үед Европын ихэнх улсуудад “Био ёс зүйн тухай” хууль, тогтоомжууд үйлчилж байсан. Дээрх хуулиуд уг конвенцид тусгалаа олсон юм. Мөн Конвенцид сүүлд нэгдэн орсон улс орнууд ёс зүйн тухай хуулиудыг дотооддоо шинээр бий болгосон. Энэ нь ихэвчлэн төв болон зүүн Европын улсууд байна.

2000 оны 4-р сарын 28-30-ны хооронд Монакод ЮНЕСКО ба “Хүүхдийн найз” Олон улсын холбоо /АМАДЕЙ/-тай хамтран “Био ёс зүй ба хүүхдийн эрх” сэдэвт семинар зохион байгуулж явуулсан юм. Уг семинараас био ёс зүй ба хүүхдийн эрхийн талаар гарсан санал, зөвлөмжүүдийг засгийн газрын болон

⁵ Резолюция 30-й Генеральной Конференции ЮНЕСКО. №23 от 11 ноября 1997 года.

См. В. И. Иванов. Биология и генетика - предмет международного права. // Моск. Журн. Межд. Права Спец. Вып. Декабрь. 1998. Стр. 204-210.

⁶ Права ребёнка. // Междисциплинарный научно-практический журнал. №2, 2003. Москва, 2003. Стр. 5-6

засгийн газрын бус олон улсын байгууллагуудад илгээсэн.⁷ Хүүхэд бие бялдрын болон оюун ухааны хувьд төгс боловсроогүй байдгийг харгалзан түүнийг төрөхийн өмнө ч, төрсний дараа ч тусгай асрамж, хамгаалалтад, үүний дотор эрх зүйн зохих хамгаалалтыг өгөх ёстой. Уг семинар нь анх удаа био ёс зүйн салбарт хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг гаргаж тавьсан.

Эмнэлгийн салбарт хүүхдийн ашиг сонирхлыг түлхүү хамгаалахыг хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 3-р заалтад заасан байна. Үүнд: нийгмийн хангамжийн асуудал эрхэлсэн улсын болон хувийн байгууллага, шүүх засаг захиргааны болон хууль тогтоох байгууллагын аль нь ч хүүхдийн талаар аливаа үйл ажиллагаа явуулахдаа эн тэргүүнд хүүхдийн эрх ашгийг дээд зэргээр хангахад анхаарлаа хандуулна. Мөн оролцогч улсууд нь хууль ёсоор хүүхдийн төлөө хариуцлага хүлээх эцэг эх, асран хамгаалагч буюу бусад хүний эрх үүргийг анхааралдаа авч, хүүхдийн аж байдлыг сайжруулахын тулд тэднийг зайлшгүй анхааран халамжлах үүрэг хүлээж, энэ зорилгоор хууль тогтоох болон захиргааны зохистой бүхий л арга хэмжээг авна. Оролцогч улсууд хүүхдийг халамжлах, тэднийг хамгаалах үүрэг бүхий албан газар байгууллагууд, тухайлбал, эрүүлийг хамгаалах, аюулаас хамгаалах салбарт, тэдгээрийн ажилтны тоо, ажилд тэнцэх байдал, түүнчлэн үр нөлөөтэй хяналт тавих үүднээс эрх мэдэл бүхий байгууллагаас тогтоосон байхуйц нөхцлөөр хангана гэжээ.

Био ёс зүй ба хүүхдийн эрхийг хамгаалах салбарт олон янзын асуудал үүсдэг. Тухайлбал, хүүхэд хоёр ээжтэй байх явдал нэг нь өндгөн эс өгснөөр биологийн ээж болж нөгөө нь тээж төрүүлж өгснөөр физиологийн ээж болох; ижил хүйстэй хосуудын өөрийн хүүхэдтэй болох эрх; үхэж буй хүүхэд эсвэл өөр дотны хүнийг клоны аргаар амьдруулах г.м. асуудлууд өнөөдөр эрх зүйн замаар шийдвэрлүүлэхийг шаардаж байна. 1998 он хүртэл Европын ихэнх орнуудад амьд биеийг клоны аргаар бий болгохыг зөвшөөрдөггүй байсан. Өнөөдрийн байдлаар 27 оронд холбогдох хууль тогтоомжууд үйлчилж байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийг анх батлах үед хүүхдийг яг хэзээнээс хамгаалах шаардлагатай байгааг зааж өгсөн ямар ч гэрээ хэлэлцээрүүд байгаагүй. Зөвхөн хүүхдийн эрхийн Конвенцид л хүүхэд бие бялдрын болон оюун ухааны хувьд төгс боловсроогүй байдгийг харгалзан түүнийг төрөхийн өмнө ч, төрсөний дараа ч тусгай хамгаалалтанд байх шаардлагатайг онцлон заасан байна. Харин дэлхийн олон оронд одоог хүртэл хүүхдийг олдсон цагаас нь эмбрион байх үеэс нь хамгаалах асуудлаар ч хууль тогтоомжууд гаргаагүй.

Сүүлийн үед өөрийн эрүүл мэндийн талаар ямар нэгэн шийдвэр бие даан гаргах чадамжгүй хүмүүс болон хүүхдийн эд шилжүүлэн суулгах асуудалтай шууд болон шууд бус холбоотой хууль тогтоомжуудыг хэд хэдэн орнууд баталсан байна. Үүнд Алжир, Египет, ЄАБНАУ, Тунис, Зимбабве, Аргентин, Боливи, Бразил, Канад, Чили, Колумби, Коста-Рика, Куба, Доминиканы БНУ, Эквадор, Гватемаль, Гондурас, Мексик, Панам, АНУ, Венесуэл, Австри, Бельги, Кипр, Дани, Финлянд, Франц, Герман, Грек, Унгар, Итали, Энэтхэг, Индонез, Ирак, Израиль, Япон, Кувейт, Ливан, Филиппин, Сингапур, Шри-Ланка, Сири гэсэн улсууд орсон байна.

Бельги улсын хууль тогтоомжууд хүүхдэд эмчилгээний үзлэг, эмчилгээ хийлгэхэд түүний хууль ёсны төлөөлөгчдөөс зөвшөөрөл авах үүрэгтэй гэж заасан байдаг. Хэрвээ эмч, хүүхдийн хууль ёсны төлөөлөгч хоёрын эмчилгээний хагалгаа

⁷ International Bioethics committee of UNESCO (IBC). 17th session. Proceedings. November 2000. Volume 1. P. 13-15

хийх талаар санал нийцэхгүй байгаа бол хүүхдийн ашиг сонирхлыг харгалзан энэ асуудлыг шийдвэрлэх ёстой бөгөөд шүүхэд хандаж болно. Хэрвээ шуурхай эмчилгээний тусламж үзүүлэх, хууль ёсны төлөөлөгчөөс зөвшөөрөл авах боломж байгаагүй тохиолдолд эмч өөрөө зохих арга хэмжээ авч болно. Францын хуулийн системийн хандлага бас үүнтэй ижилхэн байгаа.

Австрийн эмнэлгийн тухай хуулинд 18-аас доош насны хүүхдийн хувьд зөвхөн хүүхдийн аав ээж, хууль ёсны төлөөлөгчөөс авсан зөвшөөрөлтэйгээр хийгдэх эмчилгээний жагсаалт бичигдсэн байна. Мөн 14-18 настай хүүхдийн санал эмчилгээ авах эсэх талаар аав ээж, эсхүл тэднийг орлож буй хүний шийдвэр гаргахад нэмэлт санал болдог.

Үүний хажуугаар Европын зарим орнуудад эмчилгээ авах эсэх эрхийг бүр залуу өвчтөнд олгож байна. Исланд улсын хууль 16 наснаас дээш бүх өвчтөнд энэ эрхийг олгож 12-16 насны хүүхдийн санал боломжоороо тооцно гэж онцлон заасан байна. Мөн Исландын хуулийн систем 16 наснаас дээш өвчтөнд үзлэг хийх, эмчилгээ авах үеэр оюутнууд-эмч нарыг байлгах түүнээс заавал зөвшөөрөл авах ёстой байна.

Норвегид эмчийн тухай хуулийн заалтуудын дагуу 16-аас дээш насны өвчтөнд түүний эрүүл мэндийн байдлын талаар дангаараа мэдээлэл өгөх эрхийг олгосноор аав ээж нь түүний нэрийн өмнөөс юу ч хийж чадахгүй байна. 12-16 насны хүүхдийн хувьд аав ээж, хүүхэд мэдээллийг тусдаа авч байдаг. Мөн хэрвээ хүүхэд аав ээждээ эрүүл мэндийн талаар эмчийг ямар ч мэдээлэл хэлэхгүй гэж зүтгэж эмч нь үүнийг болмоор гэж үзэж байгаа бол төрөөс ийм эрхийг олгож байна. 12-16 насны хүүхэд эмчилгээ хийлгэх зөвшөөрөл өгч болох бөгөөд 16 наснаас эхлээд бие даан өөрөө шийдвэр гарган түүнийгээ илэрхийлэх эрхтэй. Мөн энэ наснаас эхлээд охид аборт хийлгэх зөвшөөрлийг өөрөө өгч чадна.

1994 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Европ дахь өвчтөний эрхийг хамгаалах талаар зөвлөгөөн хийж 36 орны төлөөлөгчдийн оролцоотойгоор Амстердамын Тунхаглалыг баталсан байна.

Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 6-р заалтад гишүүн орнууд хүүхэд болгон амьд үлдэх эрүүл байх салшгүй эрхтэйг хүлээн зөвшөөрч амьд үлдэх, эрүүл байх эрх нь дээд хэмжээгээр хангагдах ёстой гэжээ.⁸ Улс орнууд “хүүхдийн эрүүл хөгжил” гэдгийг өргөн утгаараа хүүхдийн бие, оюун ухаан, сэтгэл зүй, нийгмийн хөгжлийг хамарч буй ойлголт гэж ойлгодог.

Хүүхдийн эрх, биоэтикийн хэм хэмжээг ноцтой зөрчсөнөөр ямар хариуцлага хүлээх нь одоог хүртэл шийдэгдээгүй байна. Олон асуудалд маргаан үүсгэж эдгээрийг шийдвэрлэх нь эмч, эсвэл судлаачийн ёс суртахууны байр сууринаас хамаардаг учраас эсрэг тэсрэг хандлагад хүргэдэг.

Орчин үеийн биотехнологи ашиглан хүүхдийн эрхийг ноцтой зөрчихийг таслан зогсоохын тулд олон улсын хэм хэмжээнд хүүхдийн эрхийг хамгаалах хэрэгтэй бөгөөд үүнд хүрэхийн тулд Хүүхдийн эрхийн тухай конвенцид олон улсын эрх зүйн хуулийг протокол болгон нэмж боловсруулж болно гэж бид үзэж байна.

⁸ E. Verhellen. Convention on the Rights of the child. Background, motivation, strategies, main themes // Leuven/ Apeldoorn Garant 1997.